БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ж.ЛХАГВАСҮРЭН

# ЗАХИАЛАГЧ ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖИЛ

2025 оны 03 дугаар сарын 12

Улаанбаатар хот

| Дд | Үзүүлэлт | 1 |
|---|---|---|
| 1 | Худалдан авах барааны нэр, зориулалт | **“Чингэлтэй дүүргийн гол гудамж зам талбайн цэвэрлэгээ хийж гүйцэтгэх ажлын гэрээ”** |
| | Хэрэгжих хугацаа | 2025 он |
| | Санхүүжилтийн эх үүсвэр | Хот тохижуулах зардал |
| | Батлагдсан төсөвт өртөг (мян.төг) | 1-р багц: **137** байршлын **630,740м$^2$** - **6,389,658,954**<br>2-р багц: **126** байршлын **473,754м$^2$** - **3,890,528,146**<br>3-р багц: **5** байршлын **109,900м$^2$** - **1,661,688,000**<br>**1м$^2$** талбайг-**70** төгрөг ба цэвэрлэгээ хийгдэх давтамжийг тооцох Батлагдсан төсвийн хүрээнд санхүүжнэ. |
| | Барааны нэр төрөл, тоо хэмжээ | 1-24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ хийгдэх нийт **268** байршил бүхий нийт гурван багц ажлын **1,218,393м$^2$** талбайг цэвэрлэх төсөв 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд |
| 2 | Техникийн тодорхойлолт, стандартын шаардлага | **НЭГДҮГЭЭР БАГЦ:**<br><br>1. Зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан мастер, дээд боловсролтой байх, мэргэжил харгалзахгүй, тухайн байгууллагад тасралтгүй 2 жил ба түүнээс дээш жил нийгмийн даатгал төлсөн байх.<br>2. ХАБ-ын ажилтан 1-ээс дээш байх, мэргэжил харгалзахгүй, тухайн байгууллагад тасралтгүй 2 жил ба түүнээс дээш жил нийгмийн даатгал төлсөн байх. |

| | | |
|---|---|---|
| | | 3. Зам талбайн үйлчлэгч *(зам талбайн үйлчлэгчийн 1 удаагийн цэвэрлэх талбай 10,000м2-аас ихгүй байна.)* зам талбайн үйлчлэгч 70-аас доошгүй үндсэн ажилтан.<br><br>**Машин, механизм:**<br>4. Зам талбайн цэвэрлэгээний тусгай зориулалтын (зам талбайн чийгтэй шүүрдлэгэ хийж, шүүрдсэн шороо сорох, цас түрэх, давс, бодис цацах, зам талбай чийглэх усалгааны зориулалттай) техник – Том шүүрдэгч авто машин 2-оос доошгүй, жижиг шүүрдэгч 2-оос доошгүй байх, тусгай зориулалтын (цас түрэх, давс, бодис цацах, зам талбай чийглэх усалгааны зориулалттай) 3-аас доошгүй авто машин гэх мэт<br>5. Хог тээврийн авто машин 2-оос доошгүй байх, Ажилчдын автобус 2-оос доошгүй байх гэх мэт.<br>**Төхөөрөмж:**<br>6. Цас буудагч – 1, гар үлээгч багаж 30-аас доошгүй, гар хадуур 30-аас доошгүй, явган зам талбайг даралттай усаар угаагч 1-ээс доошгүй гэх мэт.<br>7. Өөрийн авто бааз /дулаан гарааж/-тай байх, газар дээр очиж үзэх.<br>8. Энэ чиглэлийн үйл ажиллагааг сүүлийн 10 жил тасралтгүй эрхэлсэн, туршлагатай байх.<br><br>**ХОЁРДУГААР БАГЦ:**<br><br>1. Зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан мастер, мэргэжил харгалзахгүй, тухайн байгууллагад тасралтгүй 2 жил ба түүнээс дээш жил нийгмийн даатгал төлсөн байх.<br>2. ХАБ-ын ажилтан 1-ээс дээш байх, мэргэжил харгалзахгүй, тухайн байгууллагад тасралтгүй 2 жил ба түүнээс дээш жил нийгмийн даатгал төлсөн байх.<br>3. Зам талбайн үйлчлэгч *(зам талбайн үйлчлэгчийн 1 удаагийн цэвэрлэх талбай 10,000м2-аас ихгүй байна.)* зам талбайн үйлчлэгч 50-аас доошгүй үндсэн ажилтан.<br><br>**Машин, механизм:**<br>4. Зам талбайн цэвэрлэгээний тусгай зориулалтын (зам талбайн чийгтэй шүүрдлэгэ хийж, шүүрдсэн шороо сорох, цас түрэх, давс, бодис цацах, зам талбай чийглэх усалгааны зориулалттай) техник – Том шүүрдэгч авто машин |

| | | |
|---|---|---|
| | | 2-оос доошгүй, жижиг шүүрдэгч 2-оос доошгүй байх, тусгай зориулалтын (цас түрэх, давс, бодис цацах, зам талбай чийглэх усалгааны зориулалттай) 4-өөс доошгүй авто машин гэх мэт<br>5. Хог тээврийн авто машин 2-оос доошгүй байх, Ажилчдын автобус-2, ковш-1, Боб кат-1, Автогрейдр 1-ээс доошгүй гэх мэт<br><br>**Төхөөрөмж:**<br>6. Цас буудагч–1, гар үлээгч багаж 30-аас доошгүй, гар хадуур 30-аас доошгүй, явган зам талбайг даралттай усаар угаагч 1-ээс доошгүй гэх мэт.<br>7. Өөрийн авто бааз /дулаан гарааж/-тай байх, газар дээр очиж үзэх.<br>8. Энэ чиглэлийн үйл ажиллагааг сүүлийн 10 жил тасралтгүй эрхэлсэн, туршлагатай байх<br><br>**ГУРАВДУГААР БАГЦ:**<br>1.Зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан мастер, мэргэжил харгалзахгүй, тухайн байгууллагад тасралтгүй 3 жил ба түүнээс дээш жил нийгмийн даатгал төлсөн байх.<br>2.ХАБын ажилтан 1 байх, мэргэжил харгалзахгүй, тухайн байгууллагад тасралтгүй 3 жил ба түүнээс дээш жил нийгмийн даатгал төлсөн байх.<br>3. Зам талбайн үйлчлэгч *(зам талбайн үйлчлэгчийн 1 удаагийн цэвэрлэх талбай 10,000м2-аас ихгүй байна.)* зам талбайн үйлчлэгч 20-оос доошгүй байх ба тухайн бүсэд үндсэн болон гэрээт ажилтан байж болно.<br>4. Зам талбайн үйлчлэгч нь бусад мэргэжилтэй ажиллах хүчин болон туслах мэргэжлийн ажилчид нь үндсэн ба гэрээт ажилтан байж болно. Хэрэв гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээ ирүүлнэ.<br>**Машин, механизм:**<br>5. Зам талбайн цэвэрлэгээний тусгай зориулалтын (зам талбайн чийгтэй шүүрдлэгэ хийж, шүүрдсэн шороо сорох, цас түрэх, давс, бодис цацах, зам талбай чийглэх усалгааны зориулалттай) техник – Том шүүрдэгч авто машин 2-оос доошгүй, жижиг шүүрдэгч 2-оос доошгүй байх, тусгай зориулалтын (цас түрэх, давс, бодис цацах, зам талбай чийглэх усалгааны зориулалттай) техник 3-аас доошгүй байх гэх мэт<br>6. Хог тээврийн авто машин 1-ээс доошгүй байх, Ажилчдын автобус 2-оос доошгүй, ковш-1, Боб кат-1, байх гэх мэт.<br>**Төхөөрөмж:**<br>7. Цас буудагч–1, гар үлээгч багаж 20-оос доошгүй, гар хадуур 10-аас доошгүй, |

| | | | |
|---|---|---|---|
| | | | явган зам талбайг даралттай усаар угаагч 1-ээс доошгүй гэх мэт.<br>8. Өөрийн авто бааз /дулаан гарааж/-тай байх, газар дээр очиж үзэх.<br>9. Энэ чиглэлийн үйл ажиллагааг сүүлийн 10 жил тасралтгүй эрхэлсэн, туршлагатай байх. |
| 3 | Гэрээний тусгай нөхцөлд тусгах заалт | Төслийн менежер /Захиалагчийн хяналт, гэрээний удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Захиалагчийн томилсон байгууллага, албан тушаалтан/ | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн Б.Эрдэнэбаяр |
| | | Гэрээний хугацаа | Гэрээ байгуулснаас хойш гэрээнд заагдсан өдрөөс эхлэн ажлыг гүйцэтгэнэ. |
| | | Гэрээт ажил дуусах эцсийн хугацаа | Гэрээ байгуулснаас хойш гэрээнд заагдсан хугацаанд ажлыг гүйцэтгэнэ. |
| | | Чанарын баталгаат хугацааны шаардлага | - |
| | | Гүйцэтгэлийн төлбөр төлөх хугацаа, хуваарь | Батлагдсан төсвийн хүрээнд санхүүжнэ. |
| | | Гэрээгээр хүлээсэн хугацааг хоцроосны алданги ногдуулах хувь, хэмжээ /хоног тутамд/ | Гэрээний үнийн дүнгийн 0,1%. Нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 5%-с хэтрэхгүй байна. |
| | | Барьцаа хөрөнгийн хэмжээ /хувиар/, байрших хөрөнгийн хугацаа /сараар/ | - |
| | | Урьдчилгаа төлбөрийн баталгаа шаардах эсэх | Урьдчилгаа төлбөр олгож болно. Баталгаа нь гэрээний хугацаа дуусах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.. |
| | | Бараа хүлээн авах газар байршил: | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| | | Захиалагчаас чухал гэж үзсэн бусад зайлшгүй | 1. Хог хаягдлын тухай хууль |

| | | | |
|---|---|---|---|
| | | шаардлагын санал. Үүнд: . . . . . | 2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах, булшлах журам”-ын 32/03 дугаар тогтоол<br>3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Тогтоол өөрчлөлт оруулах тухай” 05 дугаар тогтоол<br>4. Холбогдох хууль, журмын дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд хариуцсан бүсийн нийтийн эзэмшлийн гудам, зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэх ил задгай хог хаягдалгүй байлгах, халтиргаа гуулгаагүй байлгах, хуваарийн дагуу тогтмол цэвэрлэх зэрэг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн тохиолдолд гэрээг цуцлах бөгөөд үүдэн гарах хохирлыг гүйцэтгэгч байгууллага бүрэн хариуцна. |

ХЯНАСАН: ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Х.ЭНХБАТ

БОЛОВСРУУЛСАН: ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН
МЭРГЭЖИЛТЭН Б.ЭРДЭНЭБАЯР